

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2023/162/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баян-Өлгий аймаг

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас:99417382 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Ж.Назгүл

Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	5
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал .....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20
4.5.1 Завсрын аудитын талаар .....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	20
5.1 Төлбөрийн акт .....	20
5.2 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 <b>БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgi@audit.gov.mn		<b>БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГА Ш.ЧУХАЛБУЯН ТАНАА</b>
2023.02.01	№ 15	
танай	-ны №	-т
<b>Өөрчлөлтгүй дүгнэлт</b>		
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>		
<b>Дүгнэлтийн үндэслэл</b>		
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>		
<b>Асуудлыг онцолсон хэсэг</b>		
<p>Тайлант онд Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүргийг гаалийн байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой 14 орон тоо тус байгууллагад шилжиж, 497.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 17.4 сая төгрөгийн бараа материалыг балансаас балансад шилжүүлэн авсан байна.</p>		
<b>Аудитын гол асуудал</b>		
<p>Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.</p>		
<b>Бусад асуудлын хэсэг</b>		
<p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.</p>		
<b>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</b>		
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>		

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>53,390,681.81</u></b>	<b><u>78,986,270.81</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>32</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	53,390,681.81	78,986,270.81
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	10,886,950.00
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал		10,886,950.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,465,064.00	1,321,446.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	51,925,617.81	66,777,874.81
35410	Бичиг хэргийн материал	291,000.00	100,000.00
35420	Аж ахуйн материал	9,770,410.00	3,780,170.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	14,018,910.00	10,012,750.00
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	-	-
35470	Бусад хангамжийн материал	27,845,297.81	52,884,954.81
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,931,219,724.43</u></b>	<b><u>3,953,291,963.33</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,931,219,724.43	3,953,291,963.33
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,712,632,212.39	3,734,704,451.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,228,996,033.17	2,338,530,865.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	(306,334,225.28)	(417,386,469.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	296,312,170.00	415,312,170.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(296,312,170.00)	(296,312,170.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,911,190,073.53	3,566,399,622.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,157,146,504.95)	(1,902,449,089.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,581,341.71	95,945,156.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,697,197.44)	(66,809,383.98)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,665,872.11	3,665,872.11
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,623,180.46)	(2,192,122.11)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	218,587,512.04	218,587,512.00
39301	Програм хангамж	42,927,262.00	42,927,262.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,663,749.96)	(1,663,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	177,324,000.00	177,324,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,984,610,406.24</u></b>	<b><u>4,032,278,234.14</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>

41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,984,610,406.24</b>	<b>4,032,278,234.14</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,984,610,406.24	4,032,278,234.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,204,498,119.19	5,204,498,119.19
51101	Өмч: - төрийн	5,204,498,119.19	5,204,498,119.19
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(1,219,887,712.95)	(1,172,219,885.05)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,219,887,712.95)	(1,219,887,712.95)
51220	Тайлант үеийн үр дүн	-	47,667,827.90
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,984,610,406.24</b>	<b>4,032,278,234.14</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,376,659,613.37</b>	<b>1,961,732,300.22</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,305,878,913.37</b>	<b>451,879,800.22</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,305,878,913.37	451,879,800.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,303,867,533.37	436,500,455.22
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,303,867,533.37	436,500,455.22
120009	Бусад орлого	2,011,380.00	15,379,345.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,070,780,700.00</b>	<b>1,509,852,500.00</b>
1330	<b>Төсвийн захирагчдаас</b>	1,070,780,700.00	1,509,852,500.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,070,780,700.00	1,509,852,500.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,329,719,550.32</b>	<b>1,905,847,090.13</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,329,719,550.32</b>	<b>1,905,847,090.13</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,296,938,253.64	1,877,204,250.77
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	711,021,847.94	1,011,457,652.63
210101	Үндсэн цалин	654,014,822.69	904,073,334.37
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,579,000.00	84,077,500.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	19,428,025.25	23,306,818.26
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	93,214,631.85	128,958,937.43
210201	Тэтгэврийн даатгал	93,214,631.85	128,958,937.43
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	75,375,291.83	101,032,816.00
210301	Гэрэл, цахилгаан	31,413,483.61	35,576,132.00
210302	Түлш, халаалт	43,016,972.22	64,486,676.00
210303	Цэвэр, бохир ус	944,836.00	970,008.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,869,065.70	44,074,232.58
210401	Бичиг хэрэг	3,576,200.00	3,893,400.00
210402	Тээвэр, шатахуун	16,715,800.00	21,619,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,195.70	1,808,776.58

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,669,380.00	2,640,730.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,407,490.00	5,815,386.00
210408	Бараа материал акталсны зардал		8,296,240.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	21,703,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		20,265,000.00
210502	Хоол, хүнс		1,438,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	56,389,195.00	39,495,074.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	419,600.00	2,280,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	40,177,360.00	25,023,374.00
210604	Урсгал засвар	15,792,235.00	12,191,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,000,000.00	3,073,000.00
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	3,073,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	30,241,212.00	29,427,158.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,037,274.00	22,292,230.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	490,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	2,438,300.00	2,442,320.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	134,300.00	178,400.00
210807	Газрын төлбөр	565,476.00	565,476.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,476,862.00	3,848,732.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	298,827,009.32	497,981,680.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,763,276.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	298,827,009.32	496,218,404.13
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	32,781,296.68	28,642,839.36
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	1,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,900,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	32,781,296.68	26,742,839.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,781,296.68	26,742,839.36
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,046,940,063.05</b>	<b>55,885,210.09</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	31,680.00	8,217,382.19
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	31,680.00	8,217,382.19
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(31,680.00)	(8,217,382.19)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,046,908,383.05</b>	<b>47,667,827.90</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,070,780,700.00</b>	<b>1,523,271,975.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>13,419,475.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	13,419,475.00
120009	Бусад орлого		13,419,475.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,070,780,700.00</b>	<b>1,509,852,500.00</b>
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	1,070,780,700.00	1,509,852,500.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,070,780,700.00	1,509,852,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,017,246,075.00</b>	<b>1,405,168,518.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,017,246,075.00</b>	<b>1,405,168,518.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>984,464,778.32</b>	<b>1,376,525,678.64</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	709,382,725.44	1,009,709,976.43
210101	Үндсэн цалин	394,497,825.44	526,438,729.44
210102	Нэмэгдэл	215,964,900.00	302,584,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,920,000.00	80,205,116.99
210104	Урамшуулал	59,000,000.00	100,482,130.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	92,842,374.35	128,746,743.63
210201	Тэтгэврийн даатгал	92,842,374.35	128,746,743.63
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	80,108,031.83	97,026,656.00
210301	Гэрэл, цахилгаан	31,413,483.61	35,576,132.00
210302	Түлш, халаалт	47,749,712.22	60,480,516.00
210303	Цэвэр, бохир ус	944,836.00	970,008.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,140,595.70	37,821,676.58
210401	Бичиг хэрэг	3,452,200.00	3,941,100.00
210402	Тээвэр, шатахуун	15,997,600.00	21,352,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,195.70	1,808,776.58
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,537,000.00	2,578,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,653,600.00	8,140,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	32,590,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		31,151,950.00
210502	Хоол, хүнс		1,438,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	40,710,375.00	39,153,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	740,200.00	6,456,900.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	23,574,000.00	18,720,000.00
210604	Урсгал засвар	16,396,175.00	13,976,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,000,000.00	3,073,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	3,073,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	30,280,676.00	26,496,676.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,929,000.00	22,014,000.00

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	490,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	2,254,100.00	2,254,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	184,200.00	184,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	178,900.00	178,900.00
210807	Газрын төлбөр	565,476.00	565,476.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,580,000.00	1,200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	1,906,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,906,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>32,781,296.68</b>	<b>28,642,839.36</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	1,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,900,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	32,781,296.68	26,742,839.36
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,781,296.68	26,742,839.36
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>53,534,625.00</u></b>	<b><u>118,103,457.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>53,534,625.00</b>	<b>118,103,457.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>53,534,625.00</b>	<b>118,103,457.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	53,534,625.00	118,103,457.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	53,534,625.00	118,103,457.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(53,534,625.00)</u></b>	<b><u>(118,103,457.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(0.00)</b>	<b>0.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,204,498,119.19	-	(2,266,796,096.00)		2,937,702,023.19
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-			-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>5,204,498,119.19</b>	-	<b>(2,266,796,096.00)</b>	-	2,937,702,023.19
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн			1,046,908,383.05		1,046,908,383.05
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,204,498,119.19</b>	-	<b>(1,219,887,712.95)</b>	-	3,984,610,406.24
D01	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,204,498,119.19</b>	-	<b>(172,979,329.90)</b>	-	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,204,498,119.19</b>	-	<b>(1,219,887,712.95)</b>	-	3,984,610,406.24
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			47,667,827.90		47,667,827.90
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,204,498,119.19</b>	-	<b>(1,172,219,885.05)</b>	-	4,032,278,234.14

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,510,952,500.00	1,483,109,660.64
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,510,952,500.00	1,483,109,660.64
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,509,052,500.00	1,481,209,660.64
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,028,642,000.00	1,009,709,976.43
210101	Үндсэн цалин	546,386,000.00	526,438,729.44
210102	Нэмэгдэл	302,584,000.00	302,584,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,072,000.00	80,205,116.99
210104	Урамшуулал	107,600,000.00	100,482,130.00
210105	Гэрээт ажлын хөлс		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	130,555,200.00	128,746,743.63
210201	Тэтгэврийн даатгал	130,555,200.00	128,746,743.63
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	101,911,400.00	97,026,656.00
210301	Гэрэл, цахилгаан	39,268,000.00	35,576,132.00
210302	Түлш, халаалт	60,498,400.00	60,480,516.00
210303	Цэвэр, бохир ус	2,145,000.00	970,008.00
210304	Байрны түрээс		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38,285,500.00	37,821,676.58
210401	Бичиг хэрэг	3,941,100.00	3,941,100.00
210402	Тээвэр, шатахуун	21,353,300.00	21,352,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,268,500.00	1,808,776.58
210404	Ном, хэвлэл		

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,578,600.00	2,578,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,144,000.00	8,140,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	35,100,000.00	34,900,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,500,000.00	33,461,950.00
210502	Хоол, хүнс	1,600,000.00	1,438,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	141,530,000.00	141,527,582.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,030,000.00	29,030,000.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,720,000.00	18,720,000.00
210604	Урсгал засвар	93,780,000.00	93,777,582.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,000,000.00	3,073,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	3,073,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	27,121,700.00	26,496,676.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,142,500.00	22,014,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	492,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	2,254,100.00	2,254,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	184,200.00	184,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	178,900.00	178,900.00
210807	Газрын төлбөр	570,000.00	565,476.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,200,000.00	1,200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,906,700.00	1,906,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,906,700.00	1,906,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,900,000.00	1,900,000.00
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,900,000.00	1,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,900,000.00	1,900,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,510,952,500.00	1,483,109,660.64
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,510,952,500.00	1,483,109,660.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,509,852,500.00	1,483,109,660.64
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,100,000.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-
610001	Төсвийн байгууллага		

610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	64.00	60.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	40.00	35.00
620003	Үйлчлэх ажилтан	18.00	19.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>64.00</b>	<b>60.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	42.00	37.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	18.00	19.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,419,475.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,419,475.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	13,419,475.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,419,475.00
210604	Урсгал засвар	13,419,475.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	13,419,475.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	13,419,475.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,419,475.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Гаалийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэг нь гаалийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, тэдгээрт хяналт тавих, гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах гэх мэт үндсэн үүрэгтэй байгууллага юм.

Тус байгууллагын эрхэм зорилго нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хууль журмыг ашигладаг байна. Үүнд:

- ❖ Гаалийн тухай хууль
- ❖ Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль
- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ❖ Шилэн дансны тухай хууль
- ❖ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ❖ Татварын тухай хууль гэх мэт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ. Тус байгууллагад дотоод аудитын нэгж ажилладаггүй байна. ГЕГ-ын дотоод аудитаас тайлант онд шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

*Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар*

Гаалийн газар нь Гаалийн Ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/272 тоот тушаалаар баталсан Гаалийн ерөнхий газар, харьяа газар, хэлтэс, хороодод мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж ажилладаг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47.7 сая төгрөгөөр буюу 98.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	53,390.7	78,986.3	25,595.6
Үндсэн хөрөнгө	3,931,219.7	3,953,292.0	22,072.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,984,610.4</b>	<b>4,032,278.3</b>	<b>47,667.8</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,984,610.4	4,032,278.2	47,667.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,984,610.4</b>	<b>4,032,278.2</b>	<b>47,667.8</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос бараа материалын данс 25.6 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн данс 22.1 сая төгрөгөөр, Засгийн газрын хувь оролцоо данс 47.7 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна. Оны эхэнд бараа материалын данс 53.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр нийт 154.1 сая төгрөгийн бараа материал худалдан авч 28.9 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй хүлээн авч, 156.6 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан бол 0.8 сая төгрөгийн үнэт цаасыг Гаалийн ерөнхий газрын балансад шилжүүлж, оны эцэст 78.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 5752.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 118.1 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч 779.7 сая төгрөгийн дансны үнэтэй, 372.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг Мэргэжлийн хяналтын газраас үнэгүй шилжүүлэн авч, Гаалийн ерөнхий газарт 9.7 сая төгрөгийн дансны үнэтэй 2.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй машин, тоног төхөөрөмжийг шилжүүлсэн байна.

Тайлант онд Гаалийн газрын Даянгийн боомтод 13.4 сая төгрөгөөр ариутгалын пункт барих, 10.8 сая төгрөгөөр 18 метрийн урттай даралтын хийн хоолойгоор хийн шугамын угсралтын ажлыг, 20.0 сая төгрөгөөр зочид буудлын засварын ажлыг, 20.0 сая төгрөгийн хяналтын талбайн замын засвар, 5.9 сая төгрөгөөр ажилчдын 00-ын өрөөний засварын ажлыг төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгч байгууллагатай шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Тайлант хугацааны эцэст өр төлбөргүй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4032.3 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 47.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1202.4 сая, нийт зарлагыг 1202.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 307.4 зардлыг сая төгрөгөөр нэмж, 1185.9 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь Мэргэжлийн хяналтын газраас бүтцийн өөрчлөлтөөр шилжиж ирсэн Хилийн мэргэжлийн хяналтын албан хаагч нарын цалигийн зардалтай холбоотой байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 324.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1510.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1510.9 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1509.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, жилийн эцэст 26.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ. Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр 1.1 сая төгрөг батлагдсан боловч тайлант онд орлого оруулаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1483.1 сая төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 26.7 төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,100.0	-	(1,100.0)	-	
2	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,486,880.0	1,460,265.7	(26,614.3)	98	
3	80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	1,144.0	1,144.0	-	100	
4	80219-Харуул, хамгаалалтын зардал	19,928.5	19,800.0	(128.5)	99	
5	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,900.0	1,900.0	-	100	
	<b>Дүн</b>	<b>1,510,952.5</b>	<b>1,483,109.7</b>	<b>(27,842.8)</b>	<b>98</b>	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гаалийн газар нь Даянгийн боомтын ариутгалын пункт шинээр барих ажилд аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/418 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгийн сангийн эх үүсвэрээс 13.4 сая төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Аймгийн Гаалийн газарт 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/19 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Гаалийн газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1329.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 19.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг Гаалийн газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1905.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 28.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

Гаалийн газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 576.1 сая төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: цалингийн зардал, НДШ-ийн зардлаас 20.7 сая төгрөгийг, байр ашиглалтай холбоотой тогтмол зардлаас 4.9 сая төгрөгийг, хангамж бараа материалын зардлаас 0.5 сая төгрөгийг, дотоод томилолтын зардлаас 0.9 сая төгрөгийг харуул хамгаалалтын зардлаас 0.1 сая төгрөгийг тус тус хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил гараагүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад хуулийн дагуу мэдээллээ хугацаанд нь бүрэн оруулсан байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Гаалийн газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах зүйл гараагүй болно.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

#### **5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

#### **5.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй

#### **5.3 Зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

---

#### **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								